

Монгол Улсын Сангийн сайд Австрали Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд ноён Жон Лангтриг хүлээн авч уулзлаа

Огноо: [2016/02/24](#), Нийтэлсэн: [Д.Эрдэнэтүяа](#), Төрөл: [Мэдээ](#)



Монгол Улсын Сангийн сайд Австрали Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд ноён Жон Лангтри (John Langtry)-г 2016 оны 2 дугаар сарын 24-ний өдөр хүлээн авч уулзлаа. Уулзалтаар хоёр улсын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй хүний нөөцийг хөгжүүлэх болон уул, уурхайн хөтөлбөрүүд амжилттай, үр өгөөжөө өгч байгааг онцлон тэмдэглэсэн.

Сайд нар хоёр улсын эдийн засаг, хөгжлийн хамтын ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын хамтын ажиллагааны боломж, бүс нутгийн болон дэлхийн эдийн засгийн хөгжлийн хандлага, манай улсын эдийн засгийн өнөөгийн хүндрэлийг даван туулахад Засгийн газраас хэрэгжүүлж буй санхүү, төсвийн бодлого төлөвлөлтийн талаар санал солилцов. Түүнчлэн Сангийн сайд ноён Жон Лангтрид цаашид хамтран ажиллах боломж их байгаа илэрхийлсэн юм.

Австрали Улсын элчин сайдын яам 2015 оны 12 дугаар сараас Монгол Улсад үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.

<https://www.mof.gov.mn/2016/02/%D0%BC%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB-%D1%83%D0%BB%D1%81%D1%8B%D0%BD-%D1%81%D0%B0%D0%BD%D0%B3%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%81%D0%B0%D0%B9%D0%B4-%D0%B0%D0%B2%D1%81%D1%82%D1%80%D0%B0%D0%BB%D0%B8-%D1%83%D0%BB/>